## Сайн сургуулийн СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН-ы шалгуур, үзүүлэлт

| Шалгуур | Нөхцөл |
|---|---|
| **Эерэг уур амьсгал** | ***Багш, удирдлага, сурагч, ажилчид гээд хүн бүр:***<br>☐ бие биенээ хүндэтгэдэг<br>☐ хүлээн зөвшөөрдөг<br>☐ урам хайрладаг<br>☐ амжилтыг нь бодитой үнэлдэг<br>☐ алдааг нь сургамж болгоход дэмжлэг үзүүлдэг<br>☐ бие биендээ туслаġ<br>☐ бүгд ажилдаа дур сонирхолтой байдаг. |
| **Бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байх** | ***Багш, ажилтнууд:***<br>☐ эерэг хүмүүжлийн арга хэрэглэдэг<br>☐ суралцагчид асуудал тулгарахад хаана хандахаа мэддэг<br>☐ сурагчдын нууцыг хадгалдаг<br>☐ бие биендээ анхаарал халамж тавьдаг<br>☐ бие махбодийн шийтгэл, бэлгийн дарамт, хүчирхийллийн аливаа хэлбэрийг хорьсон дүрэм журам баталж хэрэгжүүлдэг. |
| **Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалтгүй** | ***Сургуульд:***<br>☐ охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх хангагдсан, адил боломж олгодог<br>☐ багш ажилтнууд хүүхдийн сайн сайхны төлөө хамтран ажилладаг, багшийн ёс зүйн дүрмээ мэддэг, ухамсарладаг<br>☐ маргиналчлагдсан бүлгийн сурагчид, тэдгээрийн эцэг эх бусдын адил эрх, боломжийг эдэлдэг ба тэдний нөхцөл байдлыг байнга анхаарч ажилладаг<br>☐ сурагч болон бусад бүх талуудын ялгаатай байдлыг ойлгож хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үздэг. |
| **Өөрийгөө хөгжүүлэх боломж** | ***Сургуулийн үйл ажиллагаанд:***<br>☐ хүн бүр ямар нэг албадлага, шахалт, өрсөлдөөнгүйгээр өөрсдийн дур сонирхлыг харгалзан хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог<br>☐ төрөл бүрийн дугуйлан, секц сонгон хичээллэдэг<br>☐ сурагчид өөрсдөө үйл ажиллагаа санаачлан зохион байгуулахыг дэмждэг<br>☐ багш, удирдах болон бусад ажилтны өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагааг дэмждэг. |